



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
АРВАЙХЭЭР СУМЫН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2018 оны 09 сарын 24 өдөр

Дугаар 33

Арвайхээр

Аддиктологийн баг байгуулах тухай

“Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай” хуулийн 7.6, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 09 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан Архидан согтуурахтай тэмцэх, архины хамааралтай болон архинд донтох эмгэгтэй иргэдтэй ажиллах чиг үүрэг бүхий “Мэргэжлийн баг”, “Аддиктологийн баг”-ийн бүрэлдэхүүний 2 дахь заалтуудыг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Арвайхээр сумын архины хамааралтай болон архинд донтох өвчтэй иргэдтэй ажиллах үүрэг бүхий Аддиктологийн багийг хавсралтаар баталсугай.

2. Архины хамааралтай болон архинд донтох өвчтэй иргэдтэй ажиллах ажиллагааг төрийн болон төрийн бус байгууллага, АА-ын бүлэг, хороодтой хамтран ажиллах үйл ажиллагааг өргөжүүлж, цаашид тогтвортой ажиллах нөхцөлийг бүрдүүлж ажиллахыг ЗДТГазрын Төрийн захиргааны ажил хариуцсан түшмэл, Аддиктологийн багийн нарийн бичгийн дарга /Ц.Гантулга/, гишүүдэд тус тус үүрэг болгосугай.

ДАРГА  ДАМАРТҮВШИН



Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
2018 оны 09 дүгээр сарын 27-ны өдрийн  
33 дугаар/дүгээр тогтоолын хавсралт

## АДДИКТОЛОГИЙН БАГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч: Сумын ИТХурлын дарга буюу сумын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөлийн дарга

Нарийн бичгийн дарга: Сумын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөлийн нарийн бичгийн дарга буюу сумын ЗДТГазрын Төрийн захиргааны ажил хариуцсан түшмэл

Гишүүд: Сумын ЗДТГазрын Нийгмийн бодлогын асуудал хариуцсан түшмэл  
Сумын ЗДТГазрын Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжил хариуцсан мэргэжилтэн

Сумын Халамжийн нийгмийн ажилтан

Багийн Нийгмийн ажилтан

ӨЭМТөвийн дарга нар

ӨЭМТөвийн Нийгмийн ажилтнууд

Багийн хэсгийн байцаагч нар

АА-ын бүлгийн ахлагч нар